



“ХӨВСГӨЛ СОРИЛТ”

УНАДАГ ДУГУЙН МӨСӨН ЗАМЫН АЯЛЛЫН ЖУРАМ

ГАРЧИГ

1	Аяллын тодорхойлолт
2	Аяллын зохион байгуулагч
3	Ерөнхий шаардлага ба журмыг хүлээн зөвшөөрөх
4	Аялалд бүртгэх нөхцөл
5	Хувцас хэрэгсэл
6	Унадаг дугуй
7	Гараа, бариа, аяллын явц
8	Оролцогчдын тодорхойлолт
9	Аяллын зам, чиглэл, аюулгүй байдал
10	Ивээн тэтгэгчид
11	Механик тусламж
12	Эмнэлэгийн тусламж ба даатгал
13	Тусламж дэмжлэг
14	Цагийн хуваарь
15	Дагалдан явагч
16	Аяллын бусад ачаа
17	Хэвлэл мэдээлэл ба зургийн эрх
18	Хүрээлэн буй орчин
19	Замын хөдөлгөөний дүрэм
20	Хоноглох байр
21	Бие засах газар
22	Зэрэглэл ба шагнал
23	Хөнгөлөлтийн карт
24	Аялал цуцлагдах
25	Хууль зүйн хариуцлага

“ХӨВСГӨЛ СОРИЛТ” УНАДАГ ДУГУЙН МӨСӨН ЗАМЫН ХАВРЫН АЯЛЛЫН ЖУРАМ

1. Аяллын тодорхойлолт

- 1.1. “Хөвсгөл сорилт” унадаг дугуйн мөсөн замын хаврын аялал нь Монгол улсын Хөвсгөл нуурын мөсөн дээр болох унадаг дугуйн аялал юм.
- 1.2. Хэдийгээр энэхүү аялал нь уралдаан, тэмцээн биш боловч, дугуйчдын хүч чадал, тэсвэр тэвчээр шаардсан, хүнд сорилт болно гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй.
- 1.3. Урьдчилан тооцоолсноор аяллаас орж ирсэн орлогоос гарсан зардлыг хасаад, үлдсэн ашиг (ойролцоогоор нэг дугуйчны 235 евро) -ийг дэлхийн дулаарлын эсрэг үйлсэд хувь нэмэр оруулахад зориулагдах юм.
- 1.4. Автомашины хэрэглээ, усны хэрэглээ, нүүрсний хэрэглээ гэсэн гурван хэрэглээгээ багасгах талаар иргэдэд сурталчлан таниулах ажилд зарцуулагдах юм.

2. Аяллын зохион байгуулагч

- 2.1. МВ (Mongolian Bike) олон улсын унадаг аяллын холбоо нь албан ёсны зохион байгуулагч юм. Цаашид “Зохион байгуулагч” гэж явна.
- 2.2. МВ (Mongolian Bike) олон улсын унадаг дугуйн аяллын холбоо нь нийгэмд үйлчилдэг, ашгийн төлөө бус, төрийн бус байгууллага юм.
- 2.3. Зохион байгуулагч нь аяллын журмыг өөрсдийн үзэмжээр хэрэглэж, мөн нэмж, өөрчилж болно.
- 2.4. Аяллын журамтай холбогдолтой эцсийн шийдвэр гаргах эрхийг зохион байгуулагч эдэлнэ.
- 2.5. Зохион байгуулагч нь аялал тус бүр дээр аялал зохион байгуулах баг, түүний ахлагчийг томилон явуулна. Аяллын ахлагч зохион байгуулагчийг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3. Ерөнхий шаардлага ба журмыг хүлээн зөвшөөрөх

- 3.1. Энэхүү журам нь аюулгүй, шударга, байгаль орчинд хор хөнөөлгүй аяллыг зохион байгуулахад оршино.
- 3.2. Аялалд оролцогч бүр нь аяллын албан ёсны журмыг сайтар уншиж ойлгосон байх ба хүлээн зөвшөөрсөн тохиолдолд аялалд оролцохоор бүртгүүлж болно.
- 3.3. Энэхүү журмууд нь “Хөвсгөл сорилт” унадаг дугуйн мөсөн замын хаврын аяллын зохион байгуулагчийн тантай хийгдэх хууль ёсны гэрээг төлөөлөх болно.
- 3.4. Энэхүү журмыг биелүүлээгүй тохиолдолд зохион байгуулагч нь аялалд оролцогчийн эрхийг хасах хүртэл арга хэмжээ авна. Аяллаас хассаны

хариуцлагыг зохион байгуулагчаас хүлээхгүй бөгөөд аяллаас хассан талаар ямар нэг тайлбар хийхгүй байж болно.

- 3.5. Аялал нь биений хүчний өндөр ачаалал шаардах ба эрүүл мэнд, бие организм тань эрсдэлд орж болзошгүйг хүлээн зөвшөөрнө.
- 3.6. Аяллын явцад төхөөрөмж нь эвдрэх, шингэний дутагдалд орох, даралт ихсэх, ядрах, зам дээр бусад аялагч, ямар нэгэн хөдөлгөөнт зүйлс болон авто машинтай мөргөлдөх, осолд орох, цаг агаарын нөхцөл байдал, байгалийн гамшиг, үер ус, гал түймэр, гэмтэл бэртэл, өвчин гэх мэт ноцтой шалтгаануудаар гэмтэж бэртэх, цаашлаад нас барах зэрэг бодит эрсдлүүдийг хүлээн зөвшөөрнө.
- 3.7. Аялал зохион байгуулагдаж байгаа улсын хууль дүрмийг сахин биелүүлж, нутгийн хүмүүс болон аялалд оролцогч бусад хүмүүс, зохион байгуулагч, сайн дурын ажилтан, эмнэлэгийн ажилтнуудад хүндэтгэлтэй хандаж, тэдэнтэй зөв боловсон харьцаж, биеэ зөв авч явна.
- 3.8. Нэмэлт тусгай заалтууд энэхүү журамд багтаагүй тохиолдолд зохион байгуулагчийн шийдвэрийг дагана.
- 3.9. Аялал нь монгол, англи хэл дээр явагдана.
- 3.10. Таны зан төлөв байдал аяллын явц, аялалд оролцогч бусад этгээд (бусад дугуйчин, дагалдагч, зохион байгуулагч, сайн дурынхан болон эмнэлэгийн ажилтнууд)-ын аюулгүй байдал, сайн сайханд садаа болохгүй, аливаа өмнөх эсэргүүцэлтэй холбоотойгоор өсөрхсөн сэтгэлээр бусдад хандахгүй байна.
- 3.11. Журмын агуулга, тэдгээрийг хэрэглэхтэй холбоотой асуудлыг олны өмнө эсэргүүцэх, зохион байгуулагчийн ажилтанг гутаан доромжилбол аяллаас хасах үндэслэл болно.
- 3.12. Аяллаас түгээж буй фото зураг, албан ёсны блог, и-мэйл, веб, зар сурталчилгааны материалууд нь зохион байгуулагчийн онцгой өмч бөгөөд бичгээр зөвшөөрөл авалгүйгээр хуулж болохгүй.
- 3.13. Оролцогч нь аялал эхлэхээс өмнө цагтаа ирсэн байх ёстой.
- 3.14. Хэрвээ энэхүү журмын аль нэг заалт хууль бус, эсвэл өөр нэг шалтгаанаар даган мөрдөгдөхгүй бол зөвхөн тухайн заалтын хувьд хамаарах ба харин бусад үлдсэн зүйл заалтыг хүчин төгөлдөр даган мөрдөхөд саад болохгүй.

4. Аялалд бүртгэх нөхцөл

- 4.1. Аялалд цахим хуудсаар дамжуулан мэдээллийн маягт бөглөн бүртгүүлнэ.
- 4.2. Аялалд оролцох улсад нэвтрэх паспорт, виз, хилийн шалгалтын бүх шаардлагыг биелүүлсэн байна. Бүртгэлийн маягт бөглөхөөсөө өмнө аялал зохион байгуулагдаж буй улсын Элчин сайдын яам, консулын газраас зохих мэдээллүүдийг авч тухайн улсад нэвтрэх шаардлагыг хангасан байна.
- 4.3. Аялалд оролцох эрхийг бусдад шилжүүлэхгүй, дамжуулахгүй, өөрчлөхгүй.

- 4.4. Аялалд 18-70 насны аль ч улсын иргэнийг ялгаварлан гадуурхалгүйгээр оролцуулна.
- 4.5. Бие, эрүүл мэндийн нөхцөл нь аялалд тохирсон байна.
- 4.6. Аялалд оролцогч бүр өөрийн эрүүл мэндтэй холбоотой хариуцлагаас зохион байгуулагчийг чөлөөлөх зөвшөөрлийн маягтанд гарын үсэг зурна.
- 4.7. Дугуйчны авчрах унадаг дугуй болон хэрэглэл нь энэхүү аяллын зорилгоо биелүүлэхэд нийцэж байвал зохино.
- 4.8. Мэргэжлийн тамирчид аялалд оролцож болно.
- 4.9. Энэхүү аялалд оролцохоос өмнө дугуйчин биеийн болон хувийн бэлтгэлээ маш сайн хангасан байна.
- 4.10. Оролцогч нь ирж, буцах тасалбараа хамт авч ирнэ.

5. Хувцас хэрэгсэл

- 5.1. Оролцогч нь цаг агаарын нөхцөлд таарсан дулаан хувцас хэрэглэлээ өөрсдөө бэлтгэж ирнэ.
- 5.2. Оролцогч гэнэтийн температурын өөрчлөлтөнд бэлтгэлтэй байх хэрэгтэй.
- 5.3. Дугуйгаар аялахдаа тогтмол хамгаалалтын дуулгаа өмсөж, шүгэл, хөнгөн цагаан хальс, толгойн чийдэн, гутлын гадуур угладаг хадаас, толь, гал гаргах хэрэгсэл зэргийг заавал биедээ авч явна.
- 5.4. Дугуйчин өөрийн тоног төхөөрөмж, хэрэгслээ өөрөө авч явна. Бусад оролцогчдод өгч явуулахыг хориглоно.
- 5.5. Аяллын явцад зохион байгуулагч нь цаг агаарын нөхцлөөс шалтгаалан тоног төхөөрөмж, хувцас хэрэгслээ солихыг шаардаж болно.
- 5.6. Аялалд оролцогч өөрийн тоног төхөөрөмж, эд зүйлсээ хариуцах бөгөөд даатгалд хамруулсан байхыг зөвлөж байна.

6. Унадаг дугуй

- 6.1. Аялалд зөвхөн хоёр дугуйтай, хөлийн булчингаар ажилладаг, уулын болон цасны унадаг дугуй авчирна.
- 6.2. Унадаг дугуйн жолооны бариул, гол, дөрөө нь бусдын гар хөлийг урахгүй, арзгар ирмэггүй байх ёстой.
- 6.3. Унадаг дугуйны гадуур хаймар нь халтиргааны эсрэг хадаастай байна.
- 6.4. Унадаг дугуй нь өвлийн хүйтний аялалд тохирсон, тос, тосолгоо, тоормозны шингэн нь -25°C -т хөлдөхгүйгээр тоноглогсон байна.
- 6.5. Унадаг дугуйндаа урд, хойд гэрэл суурилуулсан байна.

7. Гараа, бариа, аяллын явц

- 7.1. Бүх оролцогчид нэгэн зэрэг гараанаас гарна.
- 7.2. Гараа эхлэхээс 10 минутын өмнө дугуйчин гарааны талбайд ирсэн байна.
- 7.3. Гараа эхэлснээс хойш 10 минутын дотор дугуйчин ирэхгүй бол тухайн өдрийн аяллаас хасаж, автомашинд сууж, аяллыг үргэлжлүүлнэ.
- 7.4. Аялал нь цагт 15 км-ийн дундаж хурдтай явна.
- 7.5. Аяллын явцад 10-15 км тутамд түр зогсож, 10-15 минут амарна. Энэ үеэр халуун ус, цай, кофе, печень, боов, зөөврийн жорлонгоор үйлчилнэ.
- 7.6. Аяллын толгой болон сүүлд зохион байгуулагч багийн зүгээс нэг нэг хүн аялалд оролцогчдыг хашиж явна.
- 7.7. Аяллын эхэнд болон төгсгөлд автомашин дагалдана.
- 7.8. Аяллын явцад ямарч тохиолдолд согтууруулах, мансууруулах бодис хэрэглэхийг хориглоно.
- 7.9. Аяллын явцад ундны усаар хангана. Ундны усыг ундны зориулалтаар хэрэглэнэ.
- 7.10. Аяллын замын ихэнхи хэсэгт гар утасны сүлжээ байхгүй болно.
- 7.11. Аялалд оролцогчид урьдчилан гаргасан зам болон зайг бүрэн дуусгах ёстой.
- 7.12. Тухайн өдрийн аялал эхлэхээс өмнө таны тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл зорилгодоо тохирч байгаа эсэхийг шалгаж баталгаажуулсан байна.

8. Оролцогчдын тодорхойлолт

- 8.1. Аяллын өмнө дугуйчин бүр хувийн дугаар, дарцаг авна.
- 8.2. Дугуйчин бүр аяллын дугаараа унадаг дугуй болон хувцсан дээрээ байнга ил харагдахаар зөв байрлуулна.
- 8.3. Оролцогч нь цаг үргэлж тухайн аяллын эмблем, тухайн улсын далбааг хадсан цээживчийг өмссөн байна.
- 8.4. Аяллын цээживчийг гадна хувцасныхаа гадуур өмсөнө. Цээживч болон дугаарыг буруу байрлуулахыг хориглоно.
- 8.5. Аяллын явцад дугаар тэмдэг нь гэмтсэн тохиолдолд холбогдох ажилтнуудад өгч солиулна.
- 8.6. Аяллын эхэнд болон сүүлд яваа зохион байгуулагчийн оролцогч нь албан ёсны өөр өнгийн хувцас өмсөж ялгарна.
- 8.7. Зохион байгуулагч болон туслах ажилтнууд, жолооч нар өөр өнгийн цээживчээр ялгарна.

9. Аяллын зам, чиглэл, аюулгүй байдал

- 9.1. Бүх оролцогчид өөрийн аюулгүй байдлыг хангаж оролцох бөгөөд энэ талаар бүрэн ойлголттой байх ёстой.
- 9.2. Аялалд оролцогч бүр албан ёсны чиглэлийг байнга дагаж, зам товчлохгүй явна.
- 9.3. Цаг агаарын байдлаас шалтгаалж аяллын замын албан ёсны тэмдэг тэмдэглэгээ хийсэх, юманд дарагдах, шатах, устах зэргээр харагдахгүй байвал хамгийн сүүлд харсан замын тэмдэг рүү буцах хэрэгтэй.
- 9.4. Толгойн газарчин дугуйчинг гүйцэж түрүүлэхгүй бөгөөд зогсвол бүгд зогсоно.
- 9.5. Оролцогч нь ямар нэгэн шалтгаанаар чиглэлээсээ гарсан тохиолдолд зам товчлохгүйгээр тухайн гарсан замаараа буцаж чиглэлдээ нэн даруй орно.
- 9.6. Албан ёсны замын маршрутыг зөрчиж замаас гарсан оролцогч нь энэхүү хугацаанд тохиолдож болох аливаа гэмтэл эрсдэлийн хариуцлагыг өөрөө хүлээх болно.
- 9.7. Аяллын ахлагч нь зайлшгүй шаардлага болон аюулгүй байдлыг харгалзан аяллын чиглэлийг хэсэгчлэн болон бүрэн өөрчилж болно.
- 9.8. Аяллын газрын зураг дээр заасан маршрут нь орон нутгийн иргэдийн өнгөрсөн жилүүдийн өвлийн улиралд автомашинаар гаргасан зам юм.
- 9.9. 2016 онд гарах автомашины мөсөн замыг 2015 оны 12 дугаар сараас эхлэн орон нутгийн иргэд гаргадаг. Тухайн жил бүр аюулгүй байдал, бартаа саадыг туулах үүднээс харилцан адилгүй зам гардаг.
- 9.10. 2016 оны мөсөн замын зураглал, мөсөн замын аюултай цэгүүдийг урьдчилан зааж, 2016 оны 01 дүгээр сард багтаан интернэтэд тавина.
- 9.11. Аяллыг нисдэг тэргээр буюу агаараас хянах боломжгүй болно.
- 9.12. Аялалд оролцогч бүр аюулгүй байдлын үүднээс GPS төхөөрөмж хэрэглэнэ.
- 9.13. Дугуйчин аяллын явцад гэмтэж аяллыг цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон, эсвэл хэт ядарсан, өвчилсөн бол тухайн оролцогчийг автомашинаар зөөнө.
- 9.14. Цаг агаар огцом өөрчлөгдөж аюултай байдал үүсвэл бүгдийг автомашинаар зөөнө.
- 9.15. Аялал төлөвлөсөн цагтаа багтахгүй харанхуй болсон бол бүх аялагчдыг дараагийн хоноглох газарт автомашинаар зөөвөрлөж хүргэнэ.
- 9.16. Ямарч нөхцөлд аяллын замын хажууд унтаж болохгүй.
- 9.17. Хөвсгөл нуурын мөс нь жил бүр 11 дүгээр сард хөлдөж, 6 дугаар сард хайлдаг. Зузаан нь 80-140 см хүртэл хөлддөг.
- 9.18. Тухайн жилийн цаг агаар, салхи, хур тунадасны хэмжээнээс хамаарч мөсөн замын зарим хэсэг цасаар хучигдсан байдаг.
- 9.19. Нуурын мөсөн дээр заримдаа салхи секундэд 20 метр хүрч шуурдаг.

9.20. Чиглэлийг зохион байгуулагчийн зүгээс туг тэмдгээр тодорхой тэмдэглэнэ.

9.21. Нуурын мөс хоёр тийш ярагдан, ус мэлтэлзэж байгааг “хар хил” гэдэг. Хар хил нь дунджаар 10-50 см өргөнтэй, нэг эргээс нөгөө эрэг хүртэл урттай үүсдэг. Шинээр гарсан хар хил шөнөдөө хөлддөг. Шинээр үүссэн хар хилийг урьдчилан явж тэмдэг, тэмдэглэгээ тавьж анхааруулна.

9.22. Нуурын мөс шахагдан түрэгдэж, овоож хөлдсөнийг “цагаан хил” гэдэг. Цагаан хил нь

50 см-ээс 6 метр хүртэл өндөртэй, нуурын нэг эргээс нөгөө эрэг хүртэл урттай үүсдэг.

Цагаан хил нь ямар ч аюулгүй юм. Цагаан хилийн намхан газраар нь тойрч, эсвэл зам гаргаж нэвтрэнэ.



Хар хил

Цагаан хил

9.23. Мөсөн дээгүүр унадаг дугуйгаар явахад дараах 3 эрсдэл байх магадлалтай.

№	Эрсдэлийн нэр	Эрсдэл	Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга зам
1	Цасан шуурга	Замаас гарах, төөрөх	Автомашиндаа сууж дараагийн хоноглох газарт хүргүүлэх
2	Харанхуй	Замаас гарах, төөрөх	Харанхуй болохоос өмнө автомашиндаа сууж дараагийн хоноглох газарт хүргүүлэх
3	Хар хил	Усанд унах	<ul style="list-style-type: none"> 👍 Замаас гарахгүй байх 👍 Толгойн автомашиныг дагах 👍 Толгойн дугуйчинг дагах 👍 “Аюултай цэг” гэсэн тэмдэг, тэмдэглэгээтэй газраар газарчингийн заавраар болгоомжтой нэвтрэх

10. Ивээн тэтгэгчид

- 10.1. Оролцогч нь зохион байгуулагчийн зүгээс өгсөн ивээн тэтгэгчийн тэмдэг, логог өөрчлөхгүй, ил харагдахаар газар байршуулна.
- 10.2. Тухайн оролцогчийн ивээн тэтгэгчийн тэмдгийг зохион байгуулагчийн зүгээс аялалд нийцээгүй гэж үзвэл хориглож болно.

11. Механик тусламж

- 11.1. Оролцогч бүр өөрийн унадаг дугуйны засвар, үйлчилгээ, цэвэрлэгээг хариуцаж, хүчин чадлыг тооцоолох хэрэгтэй.
- 11.2. Зохион байгуулагчийн зүгээс механик засвар гарсан тохиолдолд туслах зорилгоор төлбөртэй үйлчилгээ үзүүлнэ.

12. Эмнэлэгийн тусламж ба даатгал

- 12.1. Аяллын хугацаанд дугуйчинд эмнэлэгийн тусламж үзүүлэхэд мэргэжлийн эмч, сувилагч дагалдан явах болно.
- 12.2. Аялалд оролцогчид өөрсдийн тогтмол хэрэглэдэг эм, эмийн бэлдмэлийг ямагт биедээ байнга авч явна. Яваагүйн улмаас хэрэглэж чадаагүйн хариуцлагыг зохион байгуулагч тал хүлээхгүй.
- 12.3. Аялалд оролцогч ямарваа нэгэн хууч өвчтэй тохиолдолд аялалд оролцохоосоо өмнө зохион байгуулагчид мэдэгдэх үүрэгтэй.
- 12.4. Аяллын үед гарч болзошгүй осол аваарын улмаас авсан гэмтэл, бэртлийг бусад дугуйчдын тусламжтайгаар шуурхай тусламж үзүүлэх маягаар шийдвэрлэнэ.
- 12.5. Аялалд оролцогчид бүгд сайн дурын үндсэн дээр оролцох шийдвэрийг гаргах тул зохион байгуулагч нь аяллын үеэр гарсан болзошгүй осол аваар, өвчинд хариуцлага хүлээхгүй.
- 12.6. Аялалын үед өөр оролцогч гэмтэж бэртсэн тохиолдолд нэн даруй зохион байгуулагчид мэдэгдэнэ.
- 12.7. Гэмтсэн болон өвчтэй оролцогч өөрийн хүсэлтээр аяллаа зогсоож болно. Эсвэл зохион байгуулагч нь эмчтэй зөвлөлдөж, эсвэл зөвлөлдөлгүйгээр аялалд оролцуулахгүй байж болно.
- 12.8. Зохион байгуулагч нь аялалд оролцогчдын хувь хүний эрүүл мэндийн даатгалыг хариуцахгүй. Оролцогч заавал хувь хүний эрүүл мэндийн даатгалтай ирнэ.
- 12.9. Оролцогчид нь эмнэлэгийн ажилтан, албан хаагчдад эрүүл мэндийн онцгой нөхцөлд шаардлагатай бүх арга хэмжээ авах эрхийг олгоно.
- 12.10. Эрүүл мэндийн онцгой нөхцөл байдал үүссэн үед “яаралтай үед холбоо барих хүмүүс” рүү холбогдож мэдэгдэнэ.

- 12.11. Аялал зохион байгуулагдаж байгаа газарт эмнэлэг байхгүй, хамгийн ойр эмнэлэг хүртэл тээврийн хэрэгслээр олон цаг явах алс бөглүү газарт зохион байгуулагдаж байгааг хүлээн зөвшөөрнө.
- 12.12. Онцгой байдлын тусламж үйлчилгээ маш удаан хугацаанд ирэх юм уу, зарим тохиолдолд огт байхгүй газарт аялал зохион байгуулагдаж байгааг хүлээн зөвшөөрнө.
- 12.13. Эмч сувилагч зөвхөн унадаг дугуйн аяллын өдрүүдэд ажиллана.

13. Тусламж дэмжлэг

- 13.1. Тусламж дэмжлэгийг зөвхөн аялалд оролцогчдод зөвшөөрнө.
- 13.2. Аяллын бүрэлдэхүүнд ороогүй унаа машин, мотоцикл, бусад тээврийн хэрэгсэлд суух, гаднаас ямар нэг тусламж дэмжлэг авахыг хориглоно.

14. Цагийн хуваарь

- 14.1. Аялал нь тогтсон цагийн хуваарьтай байна.
- 14.2. Аялалд оролцогчид цагийн хуваарийг чанд сахих үүрэгтэй.
- 14.3. Аюулгүй байдлын шалтгаанаар зохион байгуулагч нь цагийн хуваарийг шинэчлэх, бууруулах, нэмэгдүүлэх эрхтэй. Шинэчилсэн цагийн хуваарийг тухайн шатны гараанаас өмнө зааварчилгааны үеэр оролцогчдод мэдэгдэнэ.
- 14.4. Аялал үргэлжилж байгаа үед хүрээлэн буй орчны аюулгүй байдлын үүднээс цагийн хуваарийг өөрчилж болно.
- 14.5. Өглөөний цайны төгсгөлд тухайн өдрийн аяллын талаар товч зааварчилгаа өгнө.
- 14.6. Оройн хоолны төгсгөлд өдрийн аялал болон маргаашийн гарааны цаг, техникийн асуудал болон замын талаарх мэдээллийг товч танилцуулна.

15. Дагалдан явагч

- 15.1. Дагалдан явагч хүмүүсийг толгой болон арын машинд суулгана.
- 15.2. Хэрвээ дагалдан явах хүмүүсийн тоо хэт олон болвол тусад нь автомашин гаргаж үйлчилнэ.
- 15.3. Аяллын бүрэлдэхүүнд орсноос өөр автомашин дагалдан явахыг хориглоно.
- 15.4. Хэрэв дагалдагч насанд хүрээгүй бол асран хамгаалагчийн хамт аялалд оролцоно. 12 наснаас доош бол 30 хувийн хөнгөлөлт эдэлнэ.

16. Аяллын бусад ачаа

- 16.1. Нэг аялагчид унадаг дугуйнаас гадна 0,5 кубээс томгүй нэг эсвэл хоёр цүнхийг зөвшөөрнө.
- 16.2. Цүнхийг өглөө 08:30 цагаас өмнө хооллох газрын үүдний заасан талбайд орхино.
- 16.3. Цүнхэн дээрээ нэр болон дугаараа хадаж тавина.
- 16.4. Аяллын дараа цүнхээ хооллох газрын үүднээс буцааж авна.

17. Хэвлэл мэдээлэл ба зургийн эрх

- 17.1. Зохион байгуулагч нь аяллын үйл явдлын зургийг авах бүрэн эрхтэй. Аялалд бүртгүүлснээр оролцогч зохион байгуулагчид өөрийн нэр, зураг болон бусад зүйлийг ашиглах эрхийг автоматаар олгоно.
- 17.2. Аяллын явцад хувиараа авсан зураг видеог зөвхөн хувийн зорилгоор ашиглаж болно.
- 17.3. Аяллаас түгээж буй фото зураг, албан ёсны блог, и-мэйл, зар сурталчилгааны материалууд нь зохион байгуулагчийн онцгой өмч болно. Аяллын зургийг зөвшөөрөл авалгүйгээр тараахыг хориглоно.
- 17.4. Гадны зураглаач, фото зурагчин зохион байгуулагчаас зөвшөөрөл авна.
- 17.5. Хэвлэл мэдээллийн ажилтнуудыг тусад нь автомашинаар зөөвөрлөнө.

18. Хүрээлэн буй орчин

- 18.1. Хүрээлэн буй орчиндоо аюул занал, хор хөнөөл учруулахгүйгээр амьдарч, үр хойчдоо онгон зэрлэг байгаль дэлхийгээ өвлүүлж үлдээх нь хүн төрөлхтний үүрэг гэдгийг аялалд оролцогч бүр ухамсарлаж ойлгоно.
- 18.2. Энэхүү үйл ажиллагааны спортлог шинж чанар, байгаль орчин болон орон нутгийн иргэдийг хүндэтгэх үүднээс аялагч бүр аяллыг зохион байгуулагчийн зүгээс өгөх зааварчилгаа, зөвлөмжийг чанд сахиж мөрдөх нь байгаль болон нутгийн иргэдийг хүндэтгэж хамгаалах үндэс болох юм.
- 18.3. Хөвсгөл нуурын мөс болон эрэг дээр хогны ул мөр үлдээхгүй байна. Хогийн цэгүүдийг зөвхөн хооллох ундлах цэгүүдийн эргэн тойронд байрлуулна.
- 18.4. Аяллын явцад ундааны шил, аяга, боодлын цаас эсвэл өөр аливаа хогоо хаяхыг хориглоно.
- 18.5. Аялагчид өөрсдийн унадаг дугуйгаа урсаж буй гол, горхинд угааж цэвэрлэхийг хориглоно. Урсаж буй гол, горхинд химийн гаралтай бодис, уусмал, шингэн мэтийг асгаж болохгүйг онцгой анхаарна уу. Учир нь эдгээр цөөрөм, нуур, гол, горхи нь нутгийн оршин суугчдын цорын ганц ундны усны эх үүсвэр юм.
- 18.6. Амралтын газруудад ил гал гаргахыг хатуу хориглоно.

18.7. Аялал дууссаны дараа зохион байгуулагчид тэмдэглэл, туг зэргийг байгаль орчныг хамгаалж хүндэтгэх үүднээс цуглуулан авах болно.

18.8. Нуурын мөсөн дээр хүнд, хөнгөнөөр бие засахгүй байна.

19. Замын хөдөлгөөний дүрэм

19.1. Мөсөн дээр орон нутгийн иргэдийн автомашин зорчихтой дайралдах бөгөөд баруун гарын дүрмийг барьж зөрнө.

20. Хоноглох байр

20.1. Аяллын явцад хоноглох байр нь таны өдөр тутмын байрнаас ая тухгүй байвал тухайн байдлыг хүлээн зөвшөөрнө.

20.2. Аялалд оролцогч заасан гэр, байшиндаа, заасан оронд унтана. Кэмпээс өөр газар унтаж болохгүй.

20.3. Байр сууцандаа бусдыг байлгах, хонуулахыг хориглоно.

20.4. Байранд блог хөтлөх, и-мэйл илгээх болон бусад холбоо барих зорилгоор зөөврийн компьютер ашиглуулж болно. Аяллын явцад ямарваа нэг интернэт хуудсанд нэвтрэхийг зөвшөөрөхгүй.

21. Бие засах газар

21.1. Суурин газрын жуулчны баазуудад байх үед бие засах газруудыг ашиглана.

21.2. Замын отогт зөөврийн гялгар ууттай жорлонд бие засна. Бие зассан даруид гялгар уутныхаа амыг сайн боож хогийн саванд хийнэ.

21.3. Аяллын замд явж байх үед зөөврийн гялгар ууттай жорлонд бие засна. Бие зассан даруид гялгар уутныхаа амыг сайн боож хогийн саванд хийнэ.

22. Зэрэглэл ба шагнал 22.1. Аяллыг дуустал оролцсон оролцогч албан ёсны гэрчилгээ болон дурсгалын медаль (Finish тэмдэг) авах болно. Харин цаг агаарын нөхцөл байдлаас болж зохион байгуулагч талаас автомашинд ачсан тохиолдолд хамаарахгүй.

23. Хөнгөлөлтийн карт

23.1. MB (Mongolian Bike) олон улсын унадаг аяллын холбооноос зохион байгуулсан “Хөвсгөл сорилт” унадаг дугуйн мөсөн замын хаврын аялал, “Хөвсгөл сорилт” унадаг дугуйн бартаат замын зуны аялалд дараалан оролцсон аялагчийг клубын гишүүн болгож, дараагийн аялалд арван хувийн хөнгөлөлт эдлэх карт олгоно.

24. Аялал цуцлагдах 24.1. Орон нутгийн удирдлага цаг агаарын байдлаас болж тухайн жилийн Мөсний баярыг тэмдэглэхээргүй болсон. (Жил бүр мөсний баяр болохоос өмнө 1, 2 дугаар сард

аймгийн Засаг Даргын Тамгын газраас мэргэжлийн баг томилон явуулж, мөсний зузаан, хөлдөлтийн хэмжээг 2-3 удаагийн давтамжтайгаар шалгадаг)

24.2. Аялагчдын тоо тухайн аяллын хамгийн бага тоонд хүрээгүй.

25. Хууль зүйн хариуцлага

25.1. Оролцогч нь өөрийн болон бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд санаатай болон санаандгүй ямар нэг гэм, хор хохирол учруулахаас зайлсхийнэ.

25.2. Зохион байгуулагч тал нь санаатай ба санаандгүй, шууд ба шууд бус гэм, хохирлын төлөө ямар нэг хариуцлага хүлээхгүй

25.3. Энэхүү журмын 25.2-оос бусад тохиолдолд гарсан нэхэмжлэлийн хамгийн их үнийн дүн нь аялалд оролцсон нэг аялагчийн төлбөрөөс хэтрэхгүй байна.

25.4. Аяллын явцад үүссэн аливаа маргаантай асуудлыг харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

25.5. Маргаанаа зөвшилцөн шийдвэрлэж чадахгүй бол Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.